# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1998 оны 4 дугаар сарын 23 өдөр | Дугаар А/198 | Улаанбаатар хот

Зөвлөл байгуулах тухай

Нэг. Боловсролын тухай Монгол улсын хуулийн 15 дугаар зүйлийн 3 дугаар заалт болон Шинжлэх ухаан боловсрол, Хүн амын бодлого, Хөдөлмөрийн сайдын 1995 оны 298/210 тоот тушаалыг үндэслэн нийслэлд мэргэжлийн түр сургалт эрхлэн байгуулахад зөвшөөрөл олгох эрх бүхий зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсугай.

| | |
|---|---|
| Зөвлөлийн дарга | -Хотын ерөнхий менежер |
| Орлогч дарга | -Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн дарга |
| Нарийн бичгийн дарга | -Захирагчийн ажлын албаны Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн сургалт мэдээлэл хариуцсан мэргэжилтэн |
| Гишүүд | -Гэгээрлийн яамны сургалт хариуцсан мэргэжилтэн |
| | -Боловсролын хяналтын газрын дарга |
| | Хотын Эрүүл мэндийн газрын дарга |
| | -ХЭАХ нийгэмлэгийн дарга |
| | -Аялал жуулчлалын "Газарчин" дээд сургуулийн захирал |
| | -Тогооч нарын холбооны тэргүүн |
| | -Хүнсчдийн холбооны тэргүүн |

Хоёр. Мэргэжлийн төрөлжсөн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг хавсралтаар баталсугай.

Гурав. Тус сургалтын ажлын явцад хяналт тавьж ажиллахыг ерөнхий менежер /Н.Гомбожав/, ХЭАХ нийгэмлэг /Н.Далантай/ нарт даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1996 оны "Зөвлөл байгуулах тухай" А/151 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Ж.НАРАНЦАЦРАЛТ

Нийслэлийн Засаг даргын 1998 оны А/93
тоот захирамжийн хавсралт

### Мэргэжлийн түр сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих зөвлөлийн дүрэм

**Нэг. Зорилго**

Энэхүү зөвлөлийн зорилго нь Мэргэжлийн түр сургалт эрхлэх зөвшөөрөл олгох, сургалтын чанар, мэргэжлийн төрөлжсөн зөвлөлийн экспертизийн үнэлгээ хэр зэрэг үндэслэлтэй өгөгдсөн зэрэгт хяналт тавьж зохицуулах ,судалгаа дүн шинжилгээ хийх , түр сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх, сургалттай холбогдсон зарим арга хэмжээнүүдийг хотын хэмжээнд авч хэрэгжүүлэхэд оршино.

**Хоёр. Нийтлэг зүйл**

1. Мэргэжлийн түр сургалтын зорилго, агуулга, хөтөлбөр нь иргэдийг мэргэжил эзэмшүүлэх, тодорхой тооны ажилбарт сургах,? мэргэжлийн зэрэг ахиулах, нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.
2. Сургалт явуулах материаллаг бааз, мэргэжлийн багшаар бүрэн хангагдсан , сургалт эрхлэх зөвшөөрөл авсан байгууллага, аж ахуйн нэгж зохих хууль тогтоомжинд нийцүүлж сургалт явуулна.
3. Сургалт явуулах үйл ажиллагаа нь уг сургалт явуулах байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэсэн өдрөөс хүчин төгөлдөр болно.
4. Сургалт явуулах байгууллага, иргэд нь сонсогч, багш нар болон холбогдох байгууллагатай гэрээ байгуулах бөгөөд уг гэрээнд хоёр талын хүлээх үүрэг хариуцлагыг тусгана.
5. Зөвлөл нь Шинжлэх Ухаан Боловсрол, Хүн амын бодлого хөдөлмөрийн сайдын 1995 оны 298/210 тоот тушаалаар батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
6. Зөвлөл нь мэргэжил, салбарын онцлогийг харгалзан тодорхой үүрэг бүхий салбар төрөлжсөн зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийг хотын Ерөнхий менежерийн тушаалаар батална.

**Гурав. Мэргэжлийн түр сургалт эрхлэх зөвшөөрөл олгоход тавих шаардлага**

Дорхи шаардлагыг хангасан тохиолдолд мэргэжлийн түр сургалт эрхлэх зөвшөөрөл олгоно. Үүнд:

Сургалт явуулах байгууллага , иргэд нь зохих норм, дүрэм, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан танхимтай, мэргэжлийн онцлогт тохирсон үзүүлэн,тоног төхөөрөмж ,материаллаг баазтай,хууль дүрэм сурталчилсан булантай, журамд заасан шаардлага хангасан багшлах бүрэлдэхүүнтэй байна.

Мэргэжлийн түр сургалт зохион байгуулах сонирхолтой ,журамд заасан шаардлагыг хангасан байгууллага, иргэд зөвшөөрөл авахын тул албан бичиг, өргөдлөө Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд ирүүлнэ. Өргөдөлд дор дурдсан материалуудыг хавсаргана.

- Сургалт явуулах байгууллагын танилцуулга, аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар
- Сургалтын төлөвлөгөө
- Мэргэжлийн тодорхойлолт
- Сургалтанд хэрэглэгдэх тоног төхөөрөмжийн жагсаалт
- Багш нарын анкет
- Эдийн засгийн тооцоо

Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь өргөдөл хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор тухай мэргэжлийн төрөлжсөн зөвлөлд материалыг танилцуулж экспертиз хийлгэх ба баримт бичиг бүрдэл болоогүй тохиолдолд түүнийг хүлээн аваад сургалт эрхлэх нөхцөл бүрдсэн езж үзэл зөвшөөрөл олгох дүгнэлтийг гаргана.
Зөвлөлийн хурлыг сард нэг удаа хийнэ.
Зөвшөөрлийг Ерөнхий менежерийн тушаалаар олгоно.

Мэргэжлийн төрөлжсөн зөвлөл нь сургалтыг эхлэх, төгсөх бүрт тусгай үзүүлэлтийн дагуу шалгалт авч үнэмлэх олгох ба сургалтын амжилт зохих түвшинд хүрээгүй сургуулийн сургалтын эрхийг хасах ба багшийн багшлах эрхийг хүчингүй болгох асуудлыг зөвлөлийн хуралд оруулна.
Сургалт эрхлэх зөвшөөрөл авахаар хүсэлт тавьсан байгууллага зөвшөөрөгдсөн тохиолдолд" Тэмдэгтийн хураамжийн тухай" Монгол улсын хуулийн дагуу 12500 төгрөгийг Нийслэлийн татварын албаны дансанд, зөвшөөрлийн үнэ 3000 төгрөгийг Захирагчийн ажлын албаны дансанд тушаах ба сунгалтыг баталгаажуулахад 8000 төгрөг тушаана.
Зөвлөл нь хотын захирагчийн ажлын албаны албан бланк тэмдэг хэрэглэнэ.